

**“НЭЭЛТТЭЙ ГОВЬСҮМБЭР” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2024.05.20

Шивээговь сум

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Шаардагдах хөрөнгийн хэмжээ /сая.₮/	Биелэлт	Хувь
Зорилт 1: Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэх							
1.	Улаанбаатар хотод бүртгэлтэй боловч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн салбарыг орон нутагт бүртгэлжүүлэх.	Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо	21	25	-	Сумын хэмжээнд нийт 30 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Улаанбаатар хотод бүртгэлтэй боловч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байхгүй , бүгд орон нутгийн харьяат бүртгэлтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.	100
2.	Орон нутагт ажиллаж, амьдарч байгаа боловч шилжин ирээгүй иргэдийг шилжүүлэх, бүртгэх.	Хүн амын тоо Шилжин ирсэн иргэдийн тоо	3000 -	3600 50	-	Статистик тоон мэдээллээр 2024 он гарснаар суманд нийт 3654 иргэн амьдран, ажиллаж оршин сууж байгаагаар бүртгэгдсэн бөгөөд албан ёсоор орон нутгийн шилжүүлэг хийгдээгүй боловч хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласнаар 45 албан хаагч, тэдгээрийн хүүхэд 17, нийт 62 иргэн суманд шилжин ирээд байна. Шилжин ирсэн 45 иргэнийг салбараар нь ангилвал: <ul style="list-style-type: none"> ➢ Ерөнхий боловсролын сургуульд 10, ➢ “Шивээ-Овоо” ХК-д 15, ➢ Сургуулийн өмнөх боловсролд 4, 	100

						<p>➤ Бусад байгууллагад 16 иргэн ажиллаж, шинээр шилжин ирээд байна.</p> <p>Хүн амын тоо-3654 Шилжин ирсэн иргэдийн тоо-62</p>	
3.	Шивээговь суманд нүүрс химийн болон эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгоход бодлогоор дэмжих.	Дэмжлэгийн тоо	-	1	-	2024 он гарснаар Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нүүрс химийн болон эрчим хүчний үйлдвэрлэл байгуулах чиглэлээр санал орж ирээгүй байна.	-
4.	Орон нутагт уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, олборлолт, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллах	Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо Үйл ажиллагааны үр дүнгийн хэрэгжилт хувь	3 50	3 70	-	<p>Уул уурхайн үйлдвэрлэл, тээвэрлэлт эрхэлдэг 3 аж ахуй нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хариуцлагын хүрээнд: 2024 он гарснаар сумын хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой сэг зэм устгалын ажил, цасанд боогдсон газруудаар зам гаргах, малчин өрхүүдэд өвс тэжээл тээвэрлэх, тараах ажилд хүн хүч, машин техник бараа материалаар туслалцаа үзүүлэн ажиллаад байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ “Шивээ-Овоо” ХК сэг зэм цуглуулах, зөөх, булж устгах ажилд 5 удаа, ❖ “МАК” ХК зам гаргах, сэг зэм цуглуулж зөөж, булж устгах ажилд 12 удаа, ❖ “Страто” ХХК зам гаргах, сэг зэмийн ажилд 7 удаа тус тус явж ажилласан байна. <p>Мөн “Эйкү сора” ХХК, “Цотан жанжин транс” ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд</p>	100

						сумын малчдад өвс тэжээл тараах ажлыг 2 удаа гүйцэтгээд байна.	
5.	Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах, мөн шилжиж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтан, мэргэжилтнүүдийг ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хэрэгжилтийн хувь	1 100	1 100	-	Орон нутагт шаардлагатай мэргэжлээр шилжиж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, бусад албан хаагчдыг ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар: <ul style="list-style-type: none"> ➢ Эрүүл мэндийн төв-Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөө орон нутагт шилжин суурьшиж ажиллахаар ирсэн багийн эмчийн нийгмийн баталгааг хангах үүднээс орон нутагт ажиллах нөхцлийг бүрдүүлэн, түрээслэн амьдарч буй байрны түрээсийн төлбөрийг зургаан сарын хугацаагаар төлөөд байна. ➢ Ерөнхий боловсролын сургууль- Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын 2 өрөө байранд бага ангийн 1 багш, англи хэлний 1 багш нар амьдарч байна. 	100
Зорилт 2: Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах							
1.	Чойр хотын болон Шивээговь, Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, суурьшлын бүсийг өргөтгөх, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг сайжруулах.	Ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх	50	100	-	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбогдуулан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж эхлээд байна. Тус ажлын хүрээнд	80

						сумын Засаг даргын 2024 оны А/61 тоот захирамжаар 7-н хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан, гүйцэтгэгч компани болох “Ланд Овнер” ХХК-ийн ажлын хэсгийг 2024 оны 05 сарын 11-ний өдөр хүлээн авч уулзсан. Энэхүү уулзалтаар хээрийн болон суурин боловсруулалтын ажилд шаардлагатай материалаар ханган санал солилцон ажилласан байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар 1 компанитай хамтран ажиллаж байна.	
2.	Бизнес эрхлэгчд болон гарааны бизнесыг зээлийн болон газрын бодлогоор дэмжих	Дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо Газрын хэмжээ Зээлийн хэмжээ	2	2	-	2024 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Эрдэнэ толгойн булаг хоршооны ээлжит бус хурлыг зохион байгуулж хоршоонд ноосны урамшуулал авах зорилгоор бүртгүүлсэн гишүүдэд мэдээлэл өгөх, хоршоонд орох болон гарах хүсэлтээ өгсөн малчидтай уулзаж хоршооны ач тус, боломжийн талаар мэдээлэл өгч Шинэ хоршоо байгуулах боломж нээлттэй байгааг сурталчлан таниулж ажилласан. Эрдэнэ толгойн булаг хоршоо нь махны үйлдвэр байгуулах, хадлан бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төслөө бэлтгэж байгаа бөгөөд одоогоор зээлийн хүсэлт ирээгүй байна.	-
Зорилт 3: Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:							
1	Шилжин ирж байгаа иргэдийг орон сууцаар хангах зорилгоор	Шинээр барьсан орон сууцны тоо	-	1	ХХО	Шивээговь суманд байр орон сууц иргэдийн тоонд хүрэлцээтэй,	-

	хуучин 555 айлын орон сууцыг үе шаттай засварлах, шинээр 1200 айлын орон сууц барих ажлыг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлэх					хангалттай байгаа тул орон сууцны дэд бүтцийг нэмэгдүүлэх шаардлагагүй.	
2	Аймгийн хэмжээнд газар тариалангийн бүс нутгийг бий болгож газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих	Эргэлтийн талбайн хэмжээ Дэмжлэгийн тоо	50 га 1	100 га 2	-	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй болно.	-
3	Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжих	Эрчимжсэн аж ахуйн тоо Дэмжлэгийн тоо	3 1	6 2	ЖДҮСан ХЭДСан	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоолоор 2024 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Малын хөлийн албан татвараас зарцуулахаар “Малын үржлийн нэгж байгуулах ажил”-д 9 сая төгрөгийн төсөв батлуулаад байна. Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан малчдаас Малын хөлийн албан татвар бүрдүүлэх ажил хүлээгдээд байна.	50
4	Сумдын ундны эх үүсвэрийн судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ	-	1	-	Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулахаар алсын 1, 2 худагт 2021 оны ОНХС-ийн 19,7 сая төгрөгийн хөрөнгөөр 6 камер байршуулан хяналт тавин ажиллаж байна. Мөн өргөх станц, зүүн гэр байр, урд гэр байрны худгуудаас улирал бүр дээж авч аймгийн лаборатороор шинжлүүлэн ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Сумын ундны усны эх үүсвэр, автоматжуулалтын ажилд	100

						380,000,000 төгрөгийг баталсан. 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/18 дугаар захирамжаар “Үнэлгээний хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Техникийн тодорхойлолтыг батлуулж, нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзээд, “Толгод констракшн” ХХК шалгарч 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.	
5	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг сайжруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Шинээр байгуулсан ногоон байгууламжийн талбайн хэмжээ /га/ Тарьсан модны тоо Ургалтын хувь	7 га 52474 80 хувь	1 га 10000 85 хувь	ОНТөсөв	Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 2024 оны хаврын мод, бут тариалалт 5 дугаар сарын 17-оос эхэлсэн бөгөөд эхний байдлаар нийт 9 байгууллага 2295 ширхэг мод бутыг суулгаад байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➢ ЗДТГ-110ш шар хуайс ➢ ИШОНӨААТҮГ-1000ш шар хуайс ➢ 3-р сургууль-600 шар хуайс ➢ 3-р цэцэрлэг-200 шар хуайс ➢ Эрүүл мэндийн төв-110 ш шар хуайс, 50ш хайлаас ➢ Нарлаг шивээ СӨХ-20ш хайлаас, 35ш шар хуайс, 10ш голт бор ➢ Цагдаагийн хэсэг-30ш шар хуайс ➢ Страто ХХК-100ш хайлаас тариад байна. Ургалтын хувь 80%-тай.	100

6	Хүн амын өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Сургууль цэцэрлэгийн хүчин чадал Сургалтын чанар	75 93	100 100	Улсын төсөв	<p>Хүн амын өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Шинэ сургуулийн барилгын ажилд 2024 оны 3 сард БШУЯ болон бусад холбогдох газруудаас хяналт шалгалт хийгээд байна. Тус шалгалтаар Барилгын магадлагаа болон төсөвт өртөгийг дахин шинэчлэхээр болсон. Гүйцэтгэгч “Говийн өгөөж” ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ажлыг хүлээлцэхээр гэрээг дахин шинээр байгуулаад байна. ➤ Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг “Монничко” ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын ажил үе шатны ажлын хуваарийн дагуу цутгалт дүүргэлтийн ажил, барилгын дээврийн ажил, цахилгааны шугам дүүргэлт, хаалга, цонх хийх ажлууд хийгдэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 80%. 2024 оны 09 дүгээр сарын 01-нд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. 	80
7	Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах	Зохион байгуулсан арга хэмжээ	1	1	-	Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулахаар 2024 онд:	100

		Иргэдийн сэтгэл ханамжийн хувь	85.6	100		2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөнд 13 ажил төлөвлөгдсөн бөгөөд 10 ажил ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулагдан батлагдаж нээлттэй тендер шалгаруулалтаар цахимд зарлан ажиллаад байна. Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 5-н зорилтын хүрээнд 30-н асуумжаар 40 гаруй иргэдээс санал асуулга аваад байна.	
Дундаж биелэлт							91

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ